

**Байгалийн дэвсгэр өгүүлэмж,  
түүний урансайхны эхийн найруулгад  
гүйцэтгэх үүрэг ба утга**

**Б.Пүрэв-Очир** (УБИС)

Урансайхны эхэд найруулгын бусад төрлөөсөө ялгардаг олон онцлог шинж бий. Энэ нь юуны түрүүнд урансайхны эхийн байгууламж, зохиомж, хэл найруулга, дүр дүрслэлтэй холбоотой юм. Ер, урансайхны эхийг бүрдүүлэгч **"зохиомж"** хэмээх айд зохиолын ерөнхий байгууламж, өгүүлэгдэхүүний дараалал, зохиолын агуулга, хэлбэр, дүр бүрдэх явц, **байгалийн зураглал**, зохиолчийн тайлбар тэмдэглэл, төгсгөлийн үг зэрэг нийтлэг ойлголтуудыг багтаан үздэг байна. Бас урансайхны болон урансайхны бус эхүүд нь сонсогч эзэнд хүртэгдэх талаасаа ч үлэмж ялгаатай байдаг. Урансайхны эхийн зохиомжийг бүрдүүлж буй хэсгүүдийг **"эх задлал"**, **"эхийн өгүүлбэрзүй"**, **"discours analysis"**-ын талаас нь төдий л нарийвчлан судлаагүй иржээ. Бид энэхүү ажлын өмнөх хэсэгт урансайхны болон сонин нийтлэлийн найруулгын байгууламж, зохиомжтой холбоотой үлэмж сонин бүрдэл хэсэг болох **"эхлэл"** ба **"эхлэл үг"**-ийн талаар товч авч үзсэн билээ. Харин одоо энэ удаагийн ажиглалт судалгаанд дээрх зүйлийн залгамж холбоо болгож, **урансайхны эх дэх байгалийн дэвсгэр өгүүлэмж**, түүний үүрэг ба утгын тухай зарим зүйлийг тодруулан үзэхийг оролдов.

Урансайхны эх дэх **"Байгалийн зураглал"** хэмээх нэртомьёо бол франц хэлний **"paysage"** буюу **"газар нутаг"**, **"эх нутаг"** гэсэн утгатай үгээс үүсэл гарвалтай ажээ. Доктор Ш.Гаадамба "Уранзохиолд байгалийг дүрслэхдээ тэдгээрт хандах санаа сэтгэл, ертөцийг үзэх үзэл, яруу сайхны сэтгэлгээг илтгэх зорилготойгоор бичдэг." (1:31) гэж үзсэн байхад, доктор Д.Галбаатар "Зохиолд тодорхой зорилгоор дүрсэлж буй байгаль дэлхийн дүрслэлийг байгалийн зураглал гэж нэрлэдэг. Зохиолд баатруудын оршин амьдарч байгаа газар орон, байгалийг ерийн зурагласан байхад, нөгөө зохиолд ямар нэг баатрын амьдрал, хувь заяаны таатай, таагүй байдал хийгээд сэтгэл санааны хувирал өөрчлөлт, амьдрал тэмцлийн нөхцөл байдлыг илэрхийлэх хэрэглүүрийн үүргээр ашиглах нь бий. Ихэвчлэн тэрхүү хэрэг явдал хийгээд бий болсон нөхцөл байдалтай нийцүүлэх эсвэл харшуулах маягаар ашигладаг." (2:26) гэж тэмдэглэжээ. Тэгэхлээр байгалийн дэвсгэр өгүүлэмж, байгалийн зураглал

бол урансайхны эхийч өгүүлэмж дэх хэрэг явдлын орон, цаг хугацаа, дүрийн сэтгэл санааны байдал, гоо сайхны таашаал, хэрэг явдлын нөхцөл шалтгаан, өрнөл, нийгэм, сэтгэлзүйн орчин, дүрүүдийн хоорондын зөрчил зэргийг илэрхийлэх үүрэгтэй, хэлэх үйлдлийн уялдаа ярианы төлөвлөлтөд багтан орсон өвөрмөц онцолбор бүрэлдүүлбэр гэж үзэж болмоор байна. Чухамхүү үүний сонгодог жишээ бол Д.Нацагдоржийн алдарт **"Хуучин хүү"**-гийн дэвсгэр өгүүлэмж, зураглал болох билээ. Эл уянгын өгүүллэг буюу урансайхны эхэд:

**Хөдөөгийн байдал шалдар балдар, цагийн улирал ороо бусгаа. Элстэй шанд, буттай цайдмыг даган, хааяа нэг хар гэрээс утаа суунаглана. Дөрвөн зүг цэв цэлийн, уйтгарт цагаан униар тунана. Зуны лүгхийм халуун эсгий гэрийг шарж, малчин хүний сэтгэлийг бухимдуулна...** гэж үнэхээр сонгодог хэлбэрээр нь дүрслэн үзүүлсэн байдгийг анзаарч болох юм.

Урансайхны хүүрнэл эхүүдийг ажиглахад зарим эх ямар ч байгалийн зураглал, дэвсгэр өгүүлэмжгүй, шууд л **"үйл явдал"**-ыг эхэлсэн байдаг. Тухайлбал, Л.Түдэв **"Эрхий дарам зай"**-г **"Зураач Жамбалын бага залуугаас эхлээд хижээл насыг хүртэл үзэж өнгөрүүлсэн амьдралд нь олон янзын захиалга, үүрэг, гуйлт тохиож байлаа..."** гэж; С.Дулам **"Цэнхэр тэрлэгт"**-ийг **"Үе тэнгийн хоёр эхнэр үдмэлийг үүрч, матмалыг барьж, ухаа толгодыг нэгжин явна. Хаврын халтар хомсолоос эхлээд ноднингийн хөх аргал, уржнангийн саарал сармай аль таарсныгаа хамж, гүймлийн гээмлийг түүж явлаа..."** гэж; Ч.Галсан **"Хүү"**-г **"Тэр өглөө хүү бүр нүд нь аниастайгаар "Бороо срох гэж байна уу?" гэж асуужээ. Тэнгэр бүрхсэнийг, эсвэл ээжийнхээ дуншиж хоносныг зөнгөөрөө мэдэрсэн байж болно..."** гэж; С.Пүрэв **"Хадланчийн шөнө"**-өө **"Нуруугаа авхуулсан хөгшин морь шиг ганц хөх майхан харанхуйн дунд бөгтийнө. Дотор нь ногооны сөл ханхлуулсан таван чийрэг эр, хоёр хүүхэн бие биеийнхээ нойронд саад болохгүй гэсэн шиг нойрсоно..."** гэж; С.Хишигсүрэн **"Урилга"** өгүүллэгээ **"Долгор, наадмын өдөр гэртээ хийх ч юм олдсонгүй. Зурагт жаал харж, хонины чанасан хавирга огтолж, айраг уухаас өөр ажилгүй. Ганц бие хүн гэгч баяр наадмаар л ганцаарддаг аж..."** гэж; П.Баярсайхан **"Хоёр зуун дөчин хоёр"**-ыгоо **"Энэ нутгийг хоёр зуун дөчин хоёр гэх. Уг нь Баянтал гэдэг байлаа. Цэвэр цэнгэг гол горхи дүүрэн, хуш, нарс ч бас ургадаг газар..."** г.м.-ээр байгалийн дэвсгэр өгүүлэмжгүйгээр эхэлсэн байна.

Тэгвэл Ц.Дамдинсүрэнгийн **"Гологдсон хүүхэн"**, Д.Цэвэгмидийн **"Хоньчин Найдан"**, **"Булшин дээр"**, Д.Нацагдоржийн **"Өвлийн шөнө"**, **"Үзэгдээгүй юм"**, Б.Догмидын **"Аргагүй амраг"**, С.Эрдэнийн **"Хулан бид хоёр"**, **"Хулан, Цамба хоёр"** зэрэг урансайхны эхүүдийн байгууламж, зохиомж, хөтөлбөржилтийг ажиглахад эхийн аль нэг хэсэгт эхзохиогч, байгалийн дэвсгэр өгүүлэмж, зураглалыг ямар нэг тодорхой үүрэг, зорилготойгоор шигтгэн ашигласан байгаа нь эхийг хүртэн хүлээж авагчид хялбархан мэдрэгддэг. Тухайлбал, Д.Нацагдоржийн **"Өвлийн шөнө"** урансайхны эх (өгүүллэг)-д: байгалийн дэвсгэр өгүүлэмжийг эхлэл байдлаар: **Тасхийм хүйтэн өвлийн шөнө, тэнгэрийн одон оч шиг**

гялалзаад, уул нурууг бүрхсэн хунгар цасны хасын өнгө түүний гэрэлд алмаасын адил гэрэлтэнэ. Хүйтний жавар өмнөөс үлээгээд, голын мөс тас няс хагарна. Хөндий тал мэлцийн цэлийгээд, хааяа нэг уулын орой эрвийн сэрвийн үзэгдэнэ. Хуучин сар шөнө дундын үед цухуйхад гэрийн нохой түүнийг ширтэн, дэмий л хуцнам... (Бүрэн түүвэр, 258-р тал) гэж өвлийн шөнийн байгалийн зураг-дэвсгэр өгүүлэмжээр "урансайхны эх"-ийн эхний цогцолборыг хийж, улмаар түүний араас үйл явцыг нөхцөлдүүлэн холбож, ...Ийм нэг шөнийн гүнд холоос хэдэн морины туурай түчигнэн, хоёр хүн гадаа ирж, морийг тушин оров... гэж уялдаа ярианы дараагийн цогцолборыг байрлуулан зохиомжилсон байдаг. Тэгвэл Б.Догмидын *"Шөнө дунд шувуу жиргэдэггүй"* хүүрнэл эхийн өрнөл хэсэгт буюу дунд хэсэгт: ...Зуны шөнийн тоос тортоггүй торгон цэнхэр тэнгэрт түрүүчийн од цэцэглэн, ер бусын жавхлантай гялалзана. Уд , бургас цэцэгсийн үнэртэй зөөлөн хонгор сэвшээ салхи гэгээвчээр үе үехэн урсан орж ирнэ... гэсэн байдлаар зун цагийн байгалийн дэвсгэр өгүүлэмжийг дүрийн сэтгэлзүйтэй нийцүүлэн шигтгэн оруулсан байх жишээтэй.

Зохиолч С.Пүрэвийн *"Азын цэнхэр уул"* урансайхны хүүрнэл зохиолын баатрын (дүрийн) сэтгэл санааны таатай байдалтай нийцүүлэн өгүүлэмжийг тодосгох зорилгоор: [...] **Өгсөх тусам газар огцомхон болон, сэрүү татаж, агь гангын үнэр анхилан, алтан хараацай, унасан морины омруун дээгүүр сүвлэн нисэж эхлэв. Сэрүүн сайхан Алтай гэгч зундаа амьд бүхнээ оргилдоо дууддаг ажээ. Шувууд хүртэл цэцэг жимс, нар салхиа дагах юм даа гэж Авир ус нутгаа бахдан, "Энэ Азын цэнхэр ууланд амьд бүхэн бий. Жаргая гэсэн хүн энд төрдөг юм. Миний хүү азтай хүн юм шүү дээ. Тэр болгон хүн ийм газар, ийм эрээн алаг цэцэгс дээр хөл тавьдаг биш. Уул шигээ түшигтэй, тал шигээ сэтгэлтэй хүн яваарай."** хэмээх эцгийн захиас сургаалыг чимээгүйхэн санаж явлаа... гэсэн байгалийн дүрслэл, дэвсгэр өгүүлэмжийг маш өвөрмөцөөр байрлуулж, урансайхны эхийн зохиомж байгууламжид оруулсан байдаг.

Ингэхдээ байгалийн зураглал, дэвсгэрийг "эхлэл" байдлаар оруулах нь нийтлэг юм гэж үзэж болно. Тухайлбал, Ч.Айтматовын *"Далайн хөвөөний алаг хае толгой"* өгүүллэгт урансайхны өгүүлэмжтэй холбон нөхцөлдүүлсэн байгалийн зураглал эхлэл нь:

**Нэвтэлшгүй өтгөн манан хөвөлзсөн жихүүн шөнө Агнуурын тэнгисийн бүх эргийн дагуу, тэнгис газар хоёрын бүх фронтын дагуу мөнхийн хоёр догшин хүчтэн тэмцэлдэж, газар нь тэнгисийн түрэлтийг сөрж, тэнгис нь газар өөд эцэж цуцахыг үл мэдэн давшилсаар байлаа. Харанхуй дунд тэнгис далай энэлэн хурхирч, эргийн хавцлыг мөргөн буцна. Хатуу чулуун газар тэнгисийн давалгааны балбахыг хариулан хүчлэн уухилна. Тэнгис, газар хоёр анх бүтсэн цагаас хойш, өдөр шөнө гэж болдог болсон цагаас хойш үргэлж ингэж тэмцэлдэн ирсэн бөгөөд хойшид ч газар, ус гэж байсан цагт өдөржин, шөнөжин ингэж сөргөлдөж байх биз. Өдөржин шөнөжин [...] гэж эхлээд цааш нь: газар дэлхий дээр бас нэг шөнө өнгөрөв. Энэ бол түүний далайд явахын урд шөнө байв. Энэ шөнө тэр унтсангүй. Амьдралдаа анх унтсангүй, амьдралдаа анх удаа**

нойргүй хонож үзэв. [...] гэсэн байдлаар дараагийн цогцолбортой нь холбон найруулжээ.

С.Эрдэнийн **"Малын хөлийн тоос"** өгүүллэгт (урансайхны эхэд) **эхийн өгүүлэгдэхүүнтэй холбон нөхцөлдүүлж байгаа байгалийн зураглал эхлэл нь бас л өвөрмөц сонин юм.**

Найман сар дундаа орж, ногооны үзүүр үл мэдэгхэн модширч, хөх номин тэнгэр газраас улам холдсон мэт уужимхан цэлийж, салхи сэлүүхэн үлээх болжээ. Байгаль ертөнцийн хишиг бүрдэж, малчин ардын гэр хотлоор идээ цагаа дэлгэрсэн энэ сайхан цаг улирлын нэгэн сайхан өглөө билээ. гэж эхлээд цааш үргэлжлэхдээ Өмнө уулсын бэл улаан шаргал элсэн манхантай, умар уулсын бэл униартах ногоон дэнжтэй хангай говийг заагласан алдар цуут Борогчийн хөндийн уужим дахь борхон гэрийн эзэгтэй-гуч эргэм насны өндөр бор бүсгүй намхан зуухан дээрх тос дааварласан ширмэн тогооноос хуруу зузаан өрөм хаман авч, шар модон тавагт байгаа алгын чинээ хоёр цагаан хурууд дээр ижилхэн хувааж тавив.г.м.

Дээр дурдсан хэдэн баримт бол урансайхны эхийн доторх **"байгалийн дэвсгэр өгүүлэмж, байгалийн зураглал хэсэг"**-ийн нийтлэг байрлал юм гэж хэлж болмоор байна. Одоо, урансайхны эхийн хэл найруулга, байгууламж, зохиомж дахь байгалийн дэвсгэр өгүүлэмжийг эхзохиогчоос ямар зорилго, үүрэг, утгатайгаар эхийн найруулгад хэрэглэж, ашигладаг талаар зарим зүйлийг тодруулан авч үзье.

Хүн, байгалийн харьцаа, зохиолчийн байгаль ертөнцийг үзэх үзэл хийгээд эргэх дөрвөн цагийн жам, хүний амьдрал тэмцэл, уранзохиолд хүн ба байгалийг дүрслэх арга хэлбэр, эхзохиогчийн уран сэтгэмж, сэтгэлийн хөдөлгөөн, орон, цаг, өнгийн бэлгэдэлзүй, эхийн уялдаа яриаг хөтөлбөржүүлэн зохиох арга, түүний эхлэл ба өрнөл, төгсгөл, эдгээрийн харилцан шүтэлцээ зэргийг цогц харгалзаж, дараах байдлаар ангилан үзэж болмоор байна.

**1. Туульсын, уянгын, уянга-туульсын, эсвэл уянга-сэтгэлзүйн хүүрнэл зохиолд (урансайхны эхэд) үйл явдлын шугам, өгүүлэмж эхлэхийн өмнөх ерийн байгалийн дүрслэл буюу зураглал, түүний утга, үүрэг.**

Энэхүү ердийн эхлэл байдалтай байгалийн зураглал дүрслэлийн онцлог нь уул урансайхны эхийн үйл явдлын шугам эхэлж буй газар орон, байгалийн үзэмж байдал, цаг улирлын өнгө аясыг эхзохиогч урнаар ургуулан дүрсэлж, ихэвчлэн эхийн эхлэл хэсэгт, заримдаа дунд ба төгсгөлийн аль нэг хэсэгт байрлуулсан байдаг. Ингэхдээ байгалийн зураглал, дэвсгэр өгүүлэмжийг дүрүүдийн зөрчил, үйл явдлын өрнөлийг тодосгоход төдий л хамааралгүйгээр, зөвхөн **"үйл явдал"** өрнөхийн өмнөх орчин **"дэвсгэр"** болгох үүрэг, зорилготойгоор ашигладаг. Үүнийг батлахын тулд нэг хоёр баримт татаж харъя. Үүнд:

Д.Цэвэгмидийн *"Хоньчин Найдан"*-гийн *"Цэлмэг сайхан өдөр, хонин сүргийн дэргэд"* бол хамгийн тодорхой жишээ болох юм. Энд:

Булаг усан бургилж, цэцэг ногоо жигдэрсэн өргөн сайхан талын дунд уяхан эгшиг хангинаж, уургын үзүүр үе үе жирвэлзэнэ. Хээрийн салхи урхинаар үлээж, ногооны үзүүр намилзан халиурна.

Хүний сэтгэл тэнийм энэ уудам хээр хөдөөгийн талбарт сүрэг хонь бэлчээрлэж, яргуй цэцгийн шимтэй сайхныг эрэн, усны тунгалаг ариуныг хүснэ. Үд дунд болоход нарны илч маш халуунаар шарав. Бэлчээрийн хоньд хурж, үдшийн сэрүүн амьсгалыг хүлээхэд хоньчин Найдан тэрлэгээрээ халхавч босгоод сүүдэрт нь сууна... гэсэн ерийн байгалийн дэвсгэр өгүүлэмжийг *"үйл явдал"* эхлэхийн өмнөх орчин болгож, ашигласан байхад, Д.Нацагдоржийн *"Үзэгдээгүй юм"* урансайхны эхэд:

Хангайн сайхан нуруунаас гарсан Идэрийн сайхан гол өндөр уулнаас буусан тул, урсгал түргэн түргэн, бас л хөгжим шиг шуугина. Хажууд нь суун чагнахад үнэхээр тааламжтай. Хүний өнгөрүүлэх зам ямар болохыг юунд урьдаас тайлбарлаж үл өгнө. Энэ тунгалаг ариун мөрөн хичнээн мянган жил хэв хэвээрээ урссаар байтал, эрэг дагуу оршсон ёс, хүн амьтны түүх байн байн хувилсаар ирэх нь тэмцээний үр байжээ. Орчин тойрон зэрэглэсэн уулс бэрх өндөр, сэрвэн хад сэхийлцэн сахайлцан, сүр жавхлан хэтэрхий, ой шугуй нягт зузаан, ус булаг хоржигнон хуржигнана.

Хавцал хаднаас асгах хархираа хүрхрээ цөмөөр Идэрийн голд цутгах бөгөөд түүний цэнхэр уснаас уухад дотор сэнгэнэн сэргэнэ. Хараахан түмэн бодис дэлгэрэхийн үес, зуны тэргүүн сарын шинэдээр дорнод уулын сэрвээ дээгүүр үүрийн шар туяа гэгээрэн тусмагц энэтээ уулын орой дээр хөхөө шувуу яруухан донгодоход адуу манасан хүн түүний дууг сонсон баясч, бас баясан сонсоно. Өглөөний нар оргин гарч ирэхэд голын эхэндэх саруул хөндий гэрэлтэж, ариун агаар татан, үнэхээр зуны амьсгал анхилах бөгөөд дэрэгдэх цэцэг өвсөнд нимгэн цагаан хяруу гялтганаад, тэртээ ойд ногооны униар залгалдах нь даруй нүүдэлчин малчин хүний сэтгэлийг хөдөлгөнө... гэж үйл явдал өрнөх газар орны байгалийн өнгө төрхийг зураглан дүрсэлж, энэхүү зун цагийн байгалийн байдал нь зохиолын эцэст ...Энэ үе Идэрийн гол хэвээр урссаар... гэсэн байдалтай зохиолын үйл явдал төгсгөл болох үеийн орон цагийн байдалтай нөхцөлдөж байна.

Тэгвэл зохиолч П.Баярсайханы *"Хөх туурийн тал"* богино өгүүллэгт хүн ба байгалийн харьцаа, дүрийн сэтгэлзүйн дэвсгэр өгүүлэмжийг *"Хөх туурь бол тэнгэрийн солир харван унаж байдаг, нар өдөржин туулахдаа ч цуцдаг аугаа уужим тал нутаг. Гандаж онгосон шавар хэрмийн хэсэг бусаг үлдэц энэхүү их талын үелэх зэрэглээн дунд зүүрмэглэн байдаг юм. Хөх туурийн талын зэрэглээн дунд явахад нулимст нүдээр орчлонг харж байгаа мэт санагдана.*

Лувсан өвгөн Хөх туурийн талын хурц үнэрт навч цэцэг, өвс ногоог сүү шиг амталж, түшиж байж өндийж өссөн хүн. Амьдралынх нь баяр баясгалан, уй гашуу Хөх туурийн талд шингэжээ. Гомдол, жаргалын нулимс унагасан нь багагүй. Нулимсан дусал нь шингэсэн өвс ногоо Хөх туурийн талд ургаж, хагдарч бас дахиад л ургаж байдаг. Энэ тал нутаг, хайртай дуугий нь элгэндээ тэвэрч авчээ. Одоо тэр дууг өвгөнөөс өөр хэн ч үл мэднэ..." гэж тайлбарлан үзүүлсэн байдаг.

2. Үйл явдал үүсэж гарах нөхцөл шалтгаантай нийцүүлж харшуулсан утга, үүрэгтэй байгалийн дүрслэл, түүний онцлог.

Урансайхны болон нийтлэлийн найруулгын эхийн байгууламж, зохиомжид нэг талаар, үйл явдал үүсэн гарах, нөгөө талаар, эхлэх нөхцөл шалтгаан болгох зорилгоор байгалийн зураглалыг дэвсгэр өгүүлэмж маягтайгаар дүрсэлж, уран сэтгэмж байдлаар оруулдаг нь уг урансайхны эхийн өгүүлэмжийн шугамтай уялдан нийцэж, өгүүлэгдэхүүний эхлэх нөхцөл шалтгаан буюу уран сэтгэмжийн өмнөтгөл үүрэгтэй болж, гол төлөв тухайн эхийн эхэнд нь байрласан байдаг онцлогтой байна. Тухайлбал, ардын уран зохиолч Ц.Дамдинсүрэнгийн *"Багш, шавь хоёр"* өгүүллэгт (урансайхны эхэд):

Зуны цаг, Улаанбаатарын гудамжаар явж байтал, гудамжинд нэг цэцэг ургасан байв. Хээрийн цэцгийн үр салхинд хийсэж ирээд хотод ургаж байгаа юм байна.

Хотын хүн их төлөв зун цаг Туулын хөвөөгөөр гэр барьж зусланд суух тул зарим гудамжаар хүн явах нь цөөн болно. Ийм завшаанаар энэ цэцэг ургаж чадсан боловч зарим хүний хөлд гишгэгдэж, хотоор тэнэж явдаг ямаанд идэгдэж, тоосонд дарагдаад хээрийн цэцэгтэй зэрэгцүүлбэл их л гутанги болжээ.

Удахгүй хотын хүнийг нүүж ирэхэд энэ цэцэг хөлд гишгэгдэх нь лавтай. Хөөрхий цэцэг зохих газраа олж ургаж чадсангүй. Хэрэв цэцэрлэг юм уу байшингийн хайсанд ургасан бол өөрөө саадгүй сайн ургахын дээр хотын чимэг болж хүний сэтгэлийг баясгах зүйл болохсон билээ.

Түүний дэргэд намхан цагаан хайсны дотор түүний төрлийн нэгэн бүлэг сайхан цэцэг ургаж хурц өнгөө хүний нүдэнд тусгаж байна. Энэ цэцгийг хүн усалж арчилж байсан нь илэрхий. Үүнээс үзэхэд, аливаа юмыг бодлоготойгоор удирдах, ажиллах гэдэг их хэрэгтэй юм байна. Энэ бол зөвхөн цэцэгт ч биш, хүнд ч холбогдоно... хэмээн зохиолын өгүүлэгдэхүүний шугам эхлэх учир шалтгаан болгож, хот газрын байгалийн зурвас дүрслэл болох хайсны дотор ба гадна ургасан цэцгийг хооронд нь жишин гаргахдаа Цэцэгмаагийн амьдралын тухай өгүүлж буй утга санаа, дүрийн гадаад, дотоод шинжтэй нийцүүлэн, дэвсгэр орчин болгон дүрсэлсэн байдаг.

Зохиолч С.Пүрэв *"Элсний нүүдэл"* өгүүллэгт:

Ихсийн хоолойн тоорцог хэдэн манхан элс жилийн жилд салхинд туугдан чимээгүйрсээр нэг л мэдэхэд Дарви, Шарга хоёрыг золгуулдаг Төхөмийн бүл загийг тэр чигээр нь залгиж, зуны нартай

золгожээ. Элсний нүүдэл гэгч тэнгэрийн үүл мэт бараа сураггүй алга болдгийг тэгэхэд л би мэдэж билээ. Хэн ч анзаардаггүй энэ номхон элс он жилийн уртад их Монголын ч юм уу, Дөргөний хонхор элснээс ижил тасарч, уван цувсаар өмнө зүг өртөөлж яваа нь энэ бүлгээ... энэхүү цогцолбор эхлэл хэсэгт үйл явдал цаашид өрнөх бүхий л үйл явц, учир шалтгаан үүсэх үеийн өмнө дэвсгэр орчин болгох зорилгоор элсний нүүдэл, байгалийн хувирал өөрчлөлтийг дүрсэлсэн байна.

### 3. Үйл явдлын шугам, түүний өрнөлтийг тодосгох үүрэг бүхий байгалийн дэвсгэр дүрслэл, түүний утга.

Урансайхны болон нийтлэлийн эх дэх байгалийн дэвсгэр дүрслэлийг ажиглавал, энэ нь үйл явдлын шугамд шууд хамааралтайгаар тодосгон орж, тэрхүү байгалийн зураглалаар дамжин үйл явдлын өрнөл, зангилаа, тайлал, төгсгөл хэсэг нь өрнөн хөтөлбөрждөг онцлогтой байна. Эхийн өгүүлэмжийн дэвсгэр орчин болгож оруулсан ийм байгалийн дэвсгэр нь үйл явдлын өрнөл, зангилаа, тайлал, төгсгөл г.м. хэсгүүдтэй, нэг талаар, учирзүйгээр нөхцөлдөн нэвчиж, нөгөө талаар, эхийн зохиомжийн бүрдэл хэсгүүдтэй, нэг бол эсрэгцэн, эсвэл эерэг байдлаар шүтэлцэн тодосгон орж, уялдаа яриг бүтээх үүрэгтэй гэж үзэж болмоор байна. Нэг хоёр жишээ татаж харъя.

Зохиолч Д.Гармаагийн **“Өвгөн бүргэдийн үүр”** хэмээх нийтлэлийн найруулгын эхэд:

Холын говьд Цагаан суварга хэмээх үзэсгэлэнт нэгэн газар бий. Улаан шар, ногоон өнгөөр алаглан харагдах суваргын шавар хана зэрэглээн дунд үлгэрийн орд харш шиг харагдах нь гайхамшигтай. Хүн зориуд өөлж зассан шиг жижигхэн шавар ханатай дугана шиг дув дугараг өрөөнүүдийг усны урсгал дамжин урсч, хорвоогийн салхи шурган үлээж байдаг оройноосоо ёроолоо хүртэл нэвтрэн гарсан далдын суваг шуудууг байгаль, өөрийн жамаар үнэхээр уран сийлжээ. Одоохон савж унах нь уу гэмээр өндөр өндөр шавар багануудын нэгний оройд хэзээ ч юм бүргэд шувуу үүрээ засчээ. Тэр үүрний эргэн тойронд цагаан өнгөтэй будаг асгасан мэт өд сөд салхинаа хийснэ. Намрын адаг сарын шинэдээр нэгэн удаа буурал толгойтой, том биетэй өвгөн бүргэд мөнөөхөн үүрэн дээр явгалан суусан харагджээ. Үхэл мөхлийн цаг болоход бүргэд хүртэл үүрээ эргэн ирдэг бололтой... гэж үйл явдлын шугам, өгүүлэмжид нэвчин орох зорилго бүхий байгалийн уран сэтгэмжтэй зураглал дэвсгэрийг эхэнд нь байршуулан, улмаар үүгээр тодотгон үргэлжлүүлсээр ...Хорвоогийн өөр замаар, өөр хувь заяаны учир Готов өвгөн орхин явсан буурь бууцандаа эргэн ирэв... (“Утга зохиол урлаг” сонин, 1986. 04.4 №14) хэмээн эхийн тайлал хэсэгтэй нөхцөлдүүлсэн байдаг.

Тэгвэл зохиолч С.Эрдэнийн **“Өвгөн шувуу”** урансайхны эхийн (өгүүллэгт):

...Жаран хэдэн жил амьдарсан хорвоо ертөнц зуныхаа нэг сайхан өдрөөр түүнийг үдэн гаргаж байна уу? Наран хэвийж, агь гангын үнэр анхилмал зөөлөн бөгөөд бүлээн сэвшээ салхи үхлийн

өмнө зоригтой тайван бай гэж аргадан илбэж байх шиг. Нутгийн хөх ногоон гүвээ толгод униар дунд замхран үзэгдэх нь уужим боловч хүний насан хязгаартай, ямархан жамтай ертөнц билээ гэмээр. Энэ нар, салхи, тэнгэр, гүвээ толгодоо сүүлчийн удаа харж байна гэж Жав гуай бодож байлаа... гэсэн энэ цогцолборт эхийн үйл явдлын шугамтай шууд холбон нөхцөлдүүлэх зорилготой дэвсгэрийг шигтгэж, Жав өвгөний бодлыг тодосгох үүрэгтэйгээр хэрэглэснийг харж болно.

#### **4. Баатрын (дүрийн) зан чанар, сэтгэл санааны байдлыг тодосгох үүрэг бүхий байгалийн дэвсгэр дүрслэл, түүний утга.**

Урансайхны эхэд тухайн дүрийн сэтгэлийн дотоод ертөнц, гадаад байдлыг нээн үзүүлэхэд байгалийн дэвсгэр, зураглалыг тодорхой үүрэгтэйгээр ашиглах нь тухайн зохиол (эхийн)-ын утга санаа, дүр дүрслэлийг улам тод томруун болгож өгдөг байна. Ялангуяа дүрийн өвөрмөц онцлог, зан чанар, сэтгэлийн байдал, хувирал өөрчлөлттэй, байгаль ертөнцийн байдал, орон цагийн аясыг, нэг талаар, нийцүүлэн, нөгөө талаар, харшилдуулан дүрсэлдэг гэж үзэж болно. Тухайлбал, Д.Нацагдоржийн **“Цагаан сар ба хар нулимс”** урансайхны эхэд хаврын улирлын уур амьсгал орсон байгалийн сайхан байдлаар, зарц бүсгүй Цэрмаагийн гунигт байдлыг тодосгох үүрэг, утгатайгаар дүрсэлсэн нь хамгийн тодорхой жишээ болох билээ. Үүнд:

**Хойд уулын энгэрээр дун цагаан цас гилтгэнэн, түүний зах сэжүүр нь сэмэрч, хайлан борлосныг харахад энэ өвлийн хүйтэнд онд орж ядсан эцэнхий туранхай үхэр малууд хөл дээр гарч, үүгээр түүгээр сүүлээ ширвэн явцгаадаг нь санагдаж, тэсгэм хүйтний эрч хариад, хаврын сайхан улирал ирж байгаа нь мэдэгдэн, хэдийвээр тааламжтай сайхан байгаа боловч, малчин ардын бүсгүй Цэрмаа, Дагдангийн хаяанд зогсож, сэтгэлд их л гунигтайгаар элдэв зүйлийг бодмоглон, урт урт шүүрс алдана... гэж хавар цагийн байгалийн тааламжит байдлын дэвсгэр дээр зарц бүсгүй Цэрмаагийн сэтгэлийн гунигт байдлыг эсрэг тавьж дүрслээд, улмаар дараа дараагийн цогцолборуудтай нь уялдуулан холбосон байна.**

Дүрийг тодосгох утга, үүрэг бүхий ийм дэвсгэр өгүүлэмжийг бас **“Үзэгдээгүй юм”** өгүүллэгт (урансайхны эхэд) Балгармаагийн дотоод сэтгэлийн айдас, зэвүүцэл, хувьсгалын эсэргүү этгээдүүдийг хорсон үзэх сэтгэлийн байдлыг, тэр өдрийн байгаль, орон цагийн өнгө аястай нийцүүлэн үзүүлсэн дараах цогцолбороор баталж болно. Үүнд: **...Хөмсөг шиг шинэ саран агшин зуураа далд оров. Эсрэг этгээдээс шөнийн салхи сэр сэрхийхэд Балгармаагийн дотор жихүүцнэ. Сэтгэлийн дотор уялдаж байсан Болд үе үе үзэгдэн, үе үе үгүй болно. Аяа, учирч уулзахын заяа нэн явцуу болжээ... г.м.**

Мөн уянгын зохиолд би-баатрын өчил яриа нь дүрийн дотоод сэтгэл санааны илэрхийлэл болдог нь байгалийн дэвсгэр өгүүлэмжтэй нөхцөлдөж байдаг. Тухайлбал, зохиолч С.Эрдэнийн **“Наран тогоруу”** өгүүллэгт (урансайхны эхэд):

**...Би нутгийнхаа нартай салах ёс гүйцэтгэж байгаа учир шингэтэл нь энд сууна. Оройн саалийн цаг. Айл айлын үнээний хооронд тавьсан майн утаа найман сарын нов ногоон нуга тал**



дээгүүр алгуурхнаа суунаглан мөлхөнө. Тэрүүхэн урдах модны булгийн ойролцоо сүрэг улаан тогоруу бэлчин явна. Оройн наранд ийнхүү улайран харагднам бөгөөд дэгдээхий тогоруунууд хүчийг сорих гэсэн мэт жигүүрээ дэлгэж явгалан гүйнэ. Тэр тогоруунууд алс холоос ирдгийг мэдэх боловч "Миний нутгийн тогоруунууд баяртай" гэж дотроо би өгүүлнэм. Урд арын модны захын цэл ногоон цагдуулууд шингэх нарны гэрэлд мөн л улбар өнгөтэй болжээ. Надтай хамт өссөн тэр зулзаган моднуудыг цөмийг би танина. Булгийн эхний ганц хөгшин шинэс одоо хөгшрөөд бөв бөгтгөр болжээ. Хөгшин мод үхэж, залуу мод ургаж байдаг ёс юм бизээ... гэж би-баатрын өчил хүүрнэл яриагаар өгүүлэгчийн дотоод сэтгэлийн хандлагыг нээн гаргажээ.

##### **5. Урансайхны зохиол (эхийн) дахь дүрүүдийн хоорондын харилцаа, зөрчлийг тодосгох үүрэг бүхий байгалийн дэвсгэр өгүүлэмж, түүний утга.**

Уранзохиолд дүрийн дотоод мөн чанар, ёс суртахуун, гадаад орчин, нийгэм ахуйн нөхцөл байдлаас үүдэж, дүрүүдийн хоорондын харилцаа, зөрчил тэмцэл, ялгаа илэрч байдаг. Эх зохиогч тэрхүү харилцаа, зөрчил тэмцэл, ялгаа онцлогийг гаргахдаа байгалийн үзэгдэл, дэвсгэр өгүүлэмжийг, нэг талаар, тэрхүү зөрчилтэй шүтэлцүүлэн, нөгөө талаар, харшуулан эсрэг тавьж тодосгох утга, үүргээр ашигладаг гэж үзэж болно. Энэхүү байгалийн зураглалт дэвсгэр нь хүний аж амьдрал, нийгмийн ба хувийн харилцаа, сэтгэлийн илэрхийлэл, дүрүүдийн зан чанарыг товойлгон тодруулах утга, үүрэгтэй байдаг. Жишээлбэл, Ч.Лодойдамба гуай *"Манай сургуулийнхан"* тууждаа Ням гүн, Далхаанямбуу багш хоёрын хоорондын харилцаа, зөрчил нь сурагчдын сэтгэл санаанд хар сүүдэр туссан мэтээр хүртэгдэн ойлгогдож байгааг байгалийн үзэгдлийн хувирал өөрчлөлтөд нийцүүлэн, дараагийн үйл явдал зангирах тэр үеийн өмнөх дэвсгэр болгож тодосгосон нь сонин шийдэл болсон байдаг. Үүнд:

**...Тэнгэрт хар үүлүүд мушгиралдан нүүж, бүхнийг бараан болгон сүүдэрлээд, баруун хөтлийн цаанаас бөөн хар үүл манаран гарч ирэх нь бид бүхнийг юутай хүүтэй нь дарж аваад, хумхин базах гэж байгаа юм шиг байв...гэж дүрсэлсэн байдаг.**

Тэгвэл, Ц.Дамдинсүрэн гуай *"Чемодантай юм"* өгүүллэгтээ (урансайхны эхэд) Цээмаа, Бумаа хоёрын гадаад дүр төрх, дотоод мөн чанар, зан төлөв, амьдралын зорилго, үзэл бодлыг харьцуулан дүрслэхдээ байгалийн байдал, орчны юм үзэгдлээр дэвсгэрлэж үзүүлсэн нь маш сонин баримт болно. Үүнд:

**Зуны эхэн сарын нэг тунгалаг үдэш Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотын цэцэрлэг дотор ногоон модон вандан дээр хоёр залуухан хүүхэн сууж байна. Тэр хоёрын нэг Цээмаа хүүхэн, зааны ясан савх шиг цагаан хуруутай гараараа нуурын ус шиг долгиотсон хар гэзгээ илээд, эрвээхийн далавч шиг эрээн мяндсан алчуураараа янзаган нарийхан хүзүүгээ ороогоод, салхинд ганхсан хонгорзул цэцэг шиг гунхалзан сууж байна. Нөгөө хүүхэн Бумаа, найз Цээмаагаа харж хааяа инээмсэглэхэд түүний хөөрхөн уруулын**

цаанаас цав цагаан шүд нь шинэхэн цасан дээр тунгалаг нарны гэрэл туссан юм шиг харагдана. Эрээн мяраан хувцас өмссөн ганган Цээмаагийн дэргэд төв энгийн хувцастай цэвэрхэн бор хүүхэн Бумаагийн сууж байгаа нь тогос шувууны дэргэд хээрийн галуу сууж байгаа юм шиг харагдана.

Хоёр бүсгүйн өмнө зүлгэн дээр тарьсан алаг цэцгүүд зөөлөн салхинд найгаж, Цээмаа, Бумаа хоёрт баяр хүргэх мэт дохилзож байна. Жаргаж байгаа нар далд орохынхоо өмнө амжиж хоёр бүсгүйг сайн ажиглаж авъя гэсэн юм шиг баруун байшингийн хажуугаар шуналтайгаар шагайна.

Сайхан цэцэрлэгийн дотор муухай хогтой өндөр төмөр сав “Юуг, яаж гутаах вэ?” гэсэн юм шиг ёрдойж байна. Түүний хар сүүдэр, нар доошлох тусам улам урт болсоор Цээмааг дамжаад, Бумаагийн нарийхан шилбэн дээр тусаад, нугарч өрөөсөн хөлий нь бугуйлдаад авсан юм шиг харагдана...

Ардын уранзохиолч Ц.Дамдинсүрэн гуайн дүрслэлээс харахад урансайхны эх дэх байгалийн дэвсгэр өгүүлэмж, өнгө зураглал, сав ба шим ертөнцийн юм, үзэгдлийн орон зай, цаг хугацаа, орчин тойрны өгүүлэмж нь, нэг талаар, бэлгэдэлзүйн шинжтэй, нөгөө сөрөг талаасаа, эсрэг бэлгэдэл буюу ёрлолын утга, үүрэгтэйгээр хэрэглэгдсэн байдаг ч гэж үзэж болмоор байгаа юм.

Эцэст тэмдэглэхэд,

а) Аливаа эхийг загварчилж харвал, тодорхой үүрэг, утга бүхий мэдээллийн блокуудад хуваагддаг бөгөөд тэр нь суурь мэдээллийн, дэлгэрүүлсэн гол мэдээллийн, төгсгөл буюу дүгнэлт хэсгийн г.м. эрэмбэ байрлалтай байдаг. Тэрхүү суурь мэдээллийг нь тодосгоход байгалийн дэвсгэр өгүүлэмж, зураглал чухал үүрэгтэй бүрэлдүүлбэр болдог гэж үзэж болмоор байна.

б) Урансайхны эхийн найруулга дахь байгалийн дэвсгэр өгүүлэмж нь эхийн сэдвийн өгүүлэмжийг аль нэг талаар өргөсгөж, эх зохиогчийн бодот байдалд харьцах харьцаа, үнэлэмж, гоо сайхны таашаал, сэтгэлийн хөдөлгөөний өнгө аясыг илэрхийлсэн тийм үүрэгтэй юм гэж үзэж болно.

### Ном зохиол

1. Гаадамба, Ш., *Уранзохиолын онолын товч*, Уб., 1998
2. Галбаатар, Д., *Уранзохиолын онолын ойлголт, нэртомьёоны толь, нэмэн засварласан дөрөвдүгээр хэвлэл*, Токио., 2002.
3. Галбаатар, Д., *Монголын уранзохиолын онол түүхийн зангилаа асуудлууд; (арга, урсгал чиглэл, уламжлал шинэчлэл, үечлэл, үзэл баримтлал)*, Уб., 2001.
4. Пүрэв-Очир, Б., *Монгол хэлний эх задлалын асуудлууд, (Эхийн өгүүлбэрзүйн асуудлууд), дөтгөөр дэвтэр*, Уб., 2002.
5. Сүхбаатар, Ц., *Эхийн найруулгазүй, дэд дэвтэр*, Уб., 2002.
6. Солганик, Г.Я., *Стилистика текста*, Флинта-наука, М., 2002.
7. Чулуундорж, Б., *Когниц: сэтгэл судлал-хэлшинжлэл-мэдлэгийн онол, (лекцийн сэдвүүд)*, Уб., 2001.
8. Хүрэлбаатар, Ү., *Сонгодог уламжлал, монгол яруу найраг*, Уб., 1989.

### ABSTRACT

## Naturalistic prologue (paysage) and text of literature

B.Purev-Ochir

The author in this scholarly article specially studied one specifics of composition and stylistics of linguistic text in Mongolian language from theoretical aspect of literary linguistics and discourse analysis.

- By many factors of narration text he examined and confirmed that naturalistic presentation and naturalistic prologue are one of the important components of naturalistic prologue's structure, composition and presentation.
- Regarding the point of view of author, four seasons natural law, color changes, interrelations of human being and nature, ways of their presentation in literature, text structure, composition, programming and specifics of stylistics in complexity he divided naturalistic prologue, original narration and their roles and context in text of literature in the following five classifications and confirmed by factors:
  1. In epic, lyric, lyrical epic and lyric psychological narrations, natural presentation, natural prologue and their roles before subject line and narration;

2. Natural presentation, natural prologue and their stylistic role and context compared to and in conformity with conditions and reasons of happening of events;
3. Natural prologue, original text to determine directions and developments of events, their roles and contexts;
4. Natural presentation and natural prologue to determine moral and psychological state of character, their stylistic roles and context;
5. Natural presentation to determine interrelations between characters, their stylistic roles and context.